



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/476

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, шууд  
гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 82 дугаар дүгнэлтийн дагуу Төрийн байгууллагуудын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын 1 дүгээр багц Багийн Засаг дарга нарыг унаажуулах /Өвөрхангай/ ажлыг 179840000 (нэг зуун далан есөн сая найман зуун дөчин мянга) төгрөгөөр Баяннайман ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 5 дугаар багц Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, 7 дугаар багц Аймгийн төр захиргааны 3 дугаар байрны /Гэр бүл хүний хөгжлийн төв/ их засвар /Өвөрхангай, Арвайхээр сум/, 9 дүгээр багц Багийн төвийн барилгын тохижилт /Өвөрхангай, Тарагт сум, 6-р баг/ ажлыг хүчингүй болгож шууд гэрээ байгуулсугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудын техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэн үнийн харьцуулалт хийж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100820